

ЦАХИМ СОРИЛЫН ХЭРЭГЛЭЭ АЧ ХОЛБОГДОЛЫГ СУДЛАХ НЬ

Н.Батпүрэв¹, Ж.Сарантуяа¹, Ш.Батзүсэм¹

¹АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны Сургууль

Хүлээн авсан огноо: 2021.10.22

Хэвлэхийн зөвшөөрсөн: Редакцийн зөвлөл, доктор Л.Ариунаа

Үндэслэл

Олон улсад тархаад байгаа КОВИД-19 халдварт өвчний улмаас Монголын Их дээд сургуулиуд цар тахалтай холбоотойгоор өнгөрсөн жилээс бүх шатны сургалтын үйл ажиллагааг танхимын бус хэлбэр буюу цахим сургалт руу шилжүүлсэн. Бидний хувьд энэ ажил шинэ сорилт байлаа. Энэхүү байдлаас үүдэн цахим сургалт, цахим харилцаа манай салбарт хурдацтай нэвтэрч байна. Түүнчлэн дэлхий нийтийн хөгжлийн чиг хандлага, боловсрол дахь цахим шилжилт, иргэнд боловсрол эзэмших тэгш, хүртээмжтэй боломжийг олгохоос гадна цахим, зайны сургалт, нээлттэй нөөц материал, контентийг нэмэгдүүлж Монгол Улс дэлхий дахинаа дээд боловсролын салбарт өрсөлдөх чадвараа дээшлүүлж байна. Сургалтын үйл ажиллагааг танхимын сургалтаас гадна зайн, цахим болон холимог хэлбэрээр зохион байгуулж болох үүнийгээ дагаад багш нь танхимын бус, холимог хэлбэрийн сургалтыг зохион байгуулах мэдлэг, чадвартай байх, багшлах арга зүй, мэргэжлийн ур чадвараа тасралтгүй хөгжүүлж байна. Цахим сургалтын салшгүй нэг хэсэг бол онлайн шалгалтын систем юм. Тестийг онлайн хэлбэрээр явуулснаар тестийн үр дүнг нь хүний оролцоо байхгүй, шалгуулагч дүнгээ хурдан мэдэх бололцоотой, тест зохион байгуулагчдын хувьд хүн хүч, цаг хугацаа хэмнэх, тестийн үр дүнгээр нэгдсэн тайлан мэдээлэл гаргах нь мөн хурдан бөгөөд хялбар байна.

Судалгааны зорилго

АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн багш нарын цахим сорилын хэрэглээг судлах

Судалгааны ажлын материал, арга зүй

Судалгааг АШУУИС-ийн Говь-Алтай аймаг дахь салбар Анагаах Ухааны сургуулийн багш нарын хүрээнд 2021 онд хийсэн. Судалгаанд 30 багш хамрагдсан. Судалгааг асуумжийн аргаар хийж, үр дүнг SPSS-16 програмд боловсруулсан.

Судалгааны үр дүн

Цахим сорилыг дэмждэг эсэх-93%, Явцын болон 30 онооны шалгалтаа цахим сорилоор авдаг-97%, Хичээлийн лекцийн хэлбэрийг цахим сорилоор үнэлэх-78%, Цахим сорилын үнэлгээг бодит гэж үздэг-56% тийм, Цахим сорил хэлбэрээр шалгалт авахад ажлын ачаалал бага болсон – 46,2% хариулсан зэргээс цахим сорил ач холбогдолтойг харууллаа. Багш өөрийн цахим сорил боловсруулах мэдлэгээ үнэлэхдээ -55% нь дунд, Цахим сорил боловсруулах болон шалгалт зохион байгуулахад ямар дэмжлэг хэрэгтэй

байгаа талаар-76% нь сургалтанд хамрагдах шаардлагатай гэж үзжээ. Багш нарын 72% нь лекцийн хичээл, 68% нь семинарын хичээлийг цахим сорилоор үнэлэх зүгээр гэж үзсэн бол цахим сорил боловсруулахдаа Google forms програмыг ихэвчлэн ашигладаг байна.

Дүгнэлт

Цахим сорилыг дэмжиж байгааг тэнхмүүдийн багш нарын хувьд ялгаатай байдал ажиглагдсангүй (P=0.6). Цахим сорил сургалтандаа ашигласанаар багш нарын 96% бичгийн цаас, 80% принтерийн хорны хэрэглээ багассан нь сургуульд болон багшид эдийн засгийн хэмнэлт үүссэн байна.

ABSTRACT

It was a challenge to shift to online learning environment in all levels of education in Mongolia due to the worldwide pandemic of Covid-19 and hence instructors have urgent need to follow the international development trend in online learning, distance learning, and open course content. Moreover, we need to gain more knowledge on non-classroom learning or mixed form of learning and improve our teaching methodology. Therefore, we studied the use of online examination among the lecturers at the Gobi-Altai Medical School. Here, we used a questionnaire with 12 questions and used it on 30 lecturers. Results showed 97% applied online examination for midterm. 78% applied online test to assess students learning after lectures. 56% believe that results of online testing are reliable. 46.2% said workload decreased with the introduction of online testing. These results show that the importance of online testing is significant. When teachers assessed their knowledge applied to make online tests, 55% gave medium levels of knowledge, and 76% viewed they need training to improve their teaching methodology. 72% viewed online testing is suitable for lectures while 68% viewed it is suitable for seminars. Most use Google forms to administer online tests. 60% administer online tests through E-learning platform at the online learning center of MNUMS with the help of supervisor at the student affairs section while 16% uploaded their tests online on their own showing that lecturers' knowledge of developing online tests on E-learning platform of the university is not adequate. We conclude that there is a need to establish an online learning center equipped with right tools to make online learning contents and train teachers in online learning methods. There is a cost-cutting with the introduction of online testing since 96% of the teachers reduced their paper consumption while 80% reduced consumption of printer toner.